

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

2025.03.24

Чингис хот

НЭГ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусган зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах замаар үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГАЗҮЙ

МУ-ын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ журмын 4.4-д заасны дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэгтгэн ирүүлсэн тайлан дээр бодлого хариуцсан холбогдох мэргэжилтнээс нэмэлт тодруулга авч хийсэн болно. Хяналтад авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ журмын 6.3 -т заасан аргачлалаар үнэлэв.

ГУРАВ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ /ХШҮХ/

Нийт		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		155	8	12	17	5	59	46	2	6
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		<u>267</u>	<u>27</u>	<u>21</u>	<u>42</u>	<u>11</u>	<u>85</u>	<u>69</u>	<u>2</u>	<u>10</u>
Бүрэн хэрэгжсэн	100%	<u>217</u>	<u>24</u>	<u>16</u>	<u>36</u>	<u>11</u>	<u>69</u>	<u>51</u>	<u>1</u>	<u>9</u>
Хэрэгжих шатанд	70%	<u>40</u>	<u>3</u>	<u>4</u>	<u>5</u>	-	<u>11</u>	<u>15</u>	<u>1</u>	<u>1</u>
Хэрэгжилт хангалтгүй	30%	<u>2</u>	-	-	-	-	<u>2</u>	-	-	-
Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-
Хугацаа болоогүй	Х.Б	<u>8</u>	-	<u>1</u>	<u>1</u>	-	<u>3</u>	<u>3</u>	-	-
Биелэлтийн дундаж		94.83	96.67%	94%	96.34%	100%	94.27%	93.18%	85%	97%

Нийт 155 тогтоол шийдвэрийн 267 заалтын биелэлтийн дундаж 94.83 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс харахад хэрэгжилт хангалтгүй 4 заалт буюу санхүүжилт бүрэн шийдвэрлэгдээгүй, зохион байгуулалтын шинжтэй хэрэгжилт хангалтгүй заалтууд байна.

Хүснэгт 2-т Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2024 оны жилийн эцсийн биелэлтийн дунджийг 83 хувьтай буюу 11.83 хувиар үнэлгээ бууруулж үнэлсэн. Үнэлгээнээс харахад хэрэгжилт хангалтгүй 14 заалт, хэрэгжээгүй 9 заалт байна. /Хавсралт 1/

Хүснэгт 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ /ЗГ-ын ХХГ/

Нийт			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		155	8	12	17	5	59	46	2	6
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		<u>267</u>	<u>27</u>	<u>21</u>	<u>42</u>	<u>11</u>	<u>85</u>	<u>69</u>	<u>2</u>	<u>10</u>
Бүрэн хэрэгжсэн	100 %	152	12	3	24	4	55	49	-	5
Хэрэгжих шатанд	70%	77	10	10	11	6	19	16	-	5
Хэрэгжилт хангалтгүй	30%	14	-	2	6	-	5	1	-	-
Хэрэгжээгүй	0%	9	3	3	-	1	2	-	-	-
Нугацаа болоогүй	Х.Б	15	2	3	1	-	4	3	2	-
Биелэлтийн дундаж		83%	76%	58.8%	81.7%	74.5%	86.1%	91.6%	-	85%

Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах асуудлууд харагдаж байна.

- Хэлтэс, газрууд холбогдох асуудлаар аймгийн хэмжээний тайлан нэгтгэл гаргахгүй байгууллагын хэмжээнд хийгдсэн ажлыг тайлагнах
- Хэрэгжилт хангагдсан, өмнөх сарын хэрэгжилтээр гэх мэт журмын дагуу тайлагнаагүй
- Заалтын агуулгад тохирохгүй огт өөр зүйл тайлагнах
- Баталсан, баталгаажсан захирамжлалын баримт бичгийн огноо дугаар байхгүй, тайлан нотломжгүй, үнэмшилгүй
- Үг үсэг, утга найруулгын алдаатай, ойлгомжгүй
- Удирдлагууд тайланг хянаж баталгаажуулахгүй байх зэрэг түгээмэл зөрчлүүд илэрч байна.

ДӨРӨВ: ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй /30 хувь/, хэрэгжээгүй /0%/ үнэлэгдсэн заалтуудын хэрэгжилтийг сайжруулах болон тайлан, мэдээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэн, албан тушаалын тодорхойлолтын дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс зохион байгуулна. Хариуцсан мэргэжилтэн хэрэгжилтийг зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлагнах
- Хэрэгжилтийг тайлагнахдаа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шийдвэрийн заалтын дагуу гаргаж, өөрчлөлт, үр дүнг тоо баримтаар нотолж, үнэн зөв, мэдээллийг бүрэн гүйцэд тайлагнах
- Хэрэгжилтийг тайлагнахдаа 2000 тэмдэгтэд багтаах
- Тайланг нотлох баримтын хамт ирүүлж байх /фото зураг, график, хүснэгт/
- Хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах /шалгуур үзүүлэлт тоо эсвэл хувиар бол хэрэгжилт тоогоор эсвэл хувиар илэрхийлэгдсэн байх/
- Үнэлгээ 0, 30 хувьтай заалтуудын хэрэгжилттэй нэг бүрчлэн танилцаж, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилга гарган ажиллах, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгах, өмнөх сарын болон улирлын тайлантай харьцуулалт хийж тайлагнадаг байх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



4	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;	2022-2024 онд ашиглагдаж байгаа барилгад давхар нэмсэн, үндсэн хийц бүтцэд зохиогчийн тооцоо судалгаа, зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, барилгын даацын ханыг нураасан хийц бүтээцэд өөрчлөлт оруулж, газар хөдлөлтөд тэсвэргүй галын аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн, барилга байгууламж байхгүй байна. 2020 оноос өмнө баригдсан барилга байгууламжийн судалгаа хийгдсэн Барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх БХБС-ын албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж ажилласан.	70%	30%	Тайлант оны газар хөдлөлтийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй байна.Цаашид тайлагналтыг жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр тайлагнаж хэвших
5	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_12	1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах.	Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд, хууль тогтоомж зөрчсөн төлбөр асуудал гараагүй болно.	100%	0%	Зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ тайлагнаагүй.
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.	70%	0%	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөвт төсөвт тусгах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тайлагнах
7	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл	2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг	БЕГ-тай хамтран МУБИС-д цэцэрлэгийн 2, сургуулийн 2 багшийг тэгш хамран сургах мэргэжлийн багшийн 1 жилийн хөрвөх сургалтад хамрууллаа. Ялгаатай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамран сургах, тохирох хэрэглэгдэхүүн орчин бүрдүүлэлт, тусгай хэрэгцээт хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах арга зүй,	100%	30%	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд

	ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй сэдэвт танхимын сургалтыг 2 удаа, аутизм, даун, оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтыг цахимаар 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор цэцэрлэгийн 164 багш, сургуулийн 458 багшийг хамруулсан. Сургалтыг үе шаттай зохион байгуулснаар багш нарын арга зүй сайжирч ялгаатай хэрэгцээтэй хүүхэд тэдний эцэг эхийн харилцаа, хандлага хүүхдээ боловсролд хамруулах нь нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хэнтий аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 59 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 179 суралцагч боловсролд хамрагдаж байна. Өмнөх жилтэй харьцуулахад боловсролд хамрагдалт 15.3 хувь өссөн үзүүлэлтэй байна. Аймгийн хэмжээнд ЕБС-ийн 179, СӨБ-ын 59 багш 395.379.600 төгрөгийн урамшуулал олголоо.			нэмэгдэл хөлс олгох талаар тайлагнаагүй.
8	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	З.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ-д үйл ажиллагаа хэвийн явуулахад байрны асуудлыг хөнгөлөлтэй үнээр түрээслүүлж, өдөр өнжүүлэх төвийн асрах үйлчилгээнд байнгын асаргаа шаардлагатай 3 хүүхэд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөс эмч, сэтгэл зүйчийг урин ХБХүүхдүүд тэдгээрийн эцэг, эх асран хамгаалагч нарт “Хүүхэд бүр хөгжих боломж” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.	70%	0%	Хөгжлийн төв байгуулж, санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь хэрхэн шийдсэн талаар тайлагнаагүй.
УИХ-ын байнгын хорооны тогтоол						
9	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25	1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Орон нутгийн Политехник коллежийг түшиглэн хүнсний бүтээгдэхүүний бэлдэц бэлтгэн нийлүүлэх ажлыг эхлүүлэн политехник коллежийн дотуур байр, хэрлэн сумын 2 цэцэрлэгт зах зээлийн үнээс 14%-ийн хямдаар 7 хоногийн 2 өдөр талх нийлүүлж туршиж байна. 2024 оны хичээлийн жилд нийт 2064 талх нийлүүлээд байна.	100%	30%	Аймгийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран сургууль, цэцэрлэгийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах.

	Дугаар 2021 №05 БСШУСБХ					
10	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ	1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Хэнтий аймгийн БТСГазар нь Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвтэй хамтарч ОХУлсад 2025 оноос биеийн тамир, спортын чиглэлээр орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр их дээд сургуульд орон нутгийн оюутан залуусыг хамруулах чиглэлээр хамтарч ажиллахаар болсон. 2023 оны 12-р сарын 07- ны өдөр Б/47-р тушаалаар батлагдсан бүтэц 27 орон тоотой ажиллаж байна. Хөл бөмбөгийн дасгалжуулагч Мөнх-Од нь УБ хот руу мэргэжлийн дасгалжуулагчийн сургалтад сууж сертификат авсан.	100%	30%	Заалтын хүрээнд тайлан ирүүлэх.
11	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Энэ онд 3 сум халдваргүйтгэлийн автодук машин, 2 сум вакцин хадгалах хөргүүр, 4 сум тарилгын хашаа, 5 сум мал угаалгын суурин ванныг малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр худалдан авч малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулсан.	100%	30%	Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг эзэлж байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Өөрөөр хэлбэл нийт Малын тоо толгойн албан татварын нийт хэмжээ тодорхойгүй байна.
12	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Аймгийн ахмадын хорооны цалин хөлс болон урсгал зардалд зориулж орон нутгийн төсөвт 110,000,000 төгрөгийг тусгуулж, ахмадын хорооны байранд сар бүр аймгийн ахмадуудын дунд ахмадын шугаман бүжиг, софт гар бөмбөг, бадминтоны тэмцээнийг зохион байгуулж ажиллаж байна. Мөн ХХҮГ-н дэргэдэх Ахмадын сувилалд орон нутгийн төсвөөс 62 сая төгрөгийн үнэ бүхий 24 нэр төрлийн тоног төхөөрөмж, 30 ширхэг модон орыг шийдвэрлэж, ахмад настны амарч сувилуулах орчныг бүрдүүлсэн.	70%	30%	6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй
13	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Төсвийн төсөл боловсруулах, төлөвлөхдөө иргэд олон нийтэд аймгийн албан ёсны сайт khentii.mn, мөн shilendans.gov.mn зэргээр хүргэж ОНХСангаар хийгдэх ажлыг иргэдийн санал хураалтаар жагсаалт гарган шийдвэрлүүлж ажилласан. Мөн Төсвийн төсөл, гүйцэтгэлд өгсөн Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%	30%	Хэрэгжилтийг тайлагнаагүй бүрэн

14	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.	70%	30%	6.3.3. "хэрэгжилт хангалтгүй" - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй
Ерөнхийлөгчийн зарлиг						
15	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг 4 хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд уриалсан. Хэрэгжиж дууссан.	100%	0%	2023 оны тайланг хуулбарласан
ЗГ-ын тогтоол						
16	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2024 оны 12 дугаар сарын 19-ний байдлаар Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгын хүрээнд хангаж ажилласан. Иймд Улаанбаатар хотоос болон бусад аймгаас Хэнтий аймагт шилжин ирж Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн нийт 898 иргэн байна. Үүнээс Улаанбаатар хотоос 578 иргэн, 0-16 насны 291 хүүхэд, бусад аймгаас 320 иргэн, 0-16 насны 229 хүүхдийн хамт шилжин ирсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 19-ний байдлаар Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгын хүрээнд хангаж ажилласан. Иймд Улаанбаатар хотоос болон бусад аймгаас Хэнтий аймагт шилжин ирж Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн нийт 898 иргэн байна. Үүнээс Улаанбаатар хотоос 578 иргэн, 0-16 насны 291 хүүхэд, бусад аймгаас 320 иргэн, 0-16 насны 229 хүүхдийн хамт шилжин ирсэн байна. Хэрэгжилт	30%	30%	Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ тодорхойгүй.

			удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих			
17	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан харьяа агентлаг, байгууллага руу хүргүүлж ажилласан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусгах саналыг харьяалагдах бүх шатад уламжилсан ч тодорхой батлагдах шийдвэр гараагүй хэрэгжилт хангалтгүй байна Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	30%	30%	“хэрэгжилт хангалтгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй
18	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Сумдад нэгдсэн инженерийн шугам сүлжээг байгуулснаар эхний ээлжид Батноров суманд нийт 90 айлын 3 блок орон сууц, Норовлин суманд 30 айлын орон сууц, Биндэр суманд 24 айлын орон сууц, Бор-Өндөр суманд 30 айлын орон сууц, Бэрх тосгонд нийт 228 айлын “Санто Бэрх” орон сууцны хотхон, Бор-Өндөр суманд 36 айлын орон сууц, Дадал суманд 24 айлын орон сууц баригдахаар төлөвлөгдөөд байна.	100%	0%	6.3.4. “хэрэгжээгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй. Хийж хэрэгжүүлсэн ажил байхгүй эрчимжүүлэх шаардлагатай тул оноог бууруулав.
19	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2024-05-22 Дугаар 2024_229	3.. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл	Ашиглалт болон нөхөн сэргээлтийн явцад түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрээгүй	Х.Б	0%	Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан асуудалд

		ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус үүрэг болгосугай				хяналт тавьж ажилласан эсэх асуудлыг тайлагнах
20	Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай 2024-05-29 Дугаар 2024_239	2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай()	Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд Хэнтий-Дадал чиглэлийн авто зам, Дадал сумын нисэх онгоцны буудал, зам дагуух үйлчилгээний төв, буудаллах цэг байгуулах, орон нутгийн авто замуудын засвар үйлчилгээ, байршуулах үйлчилгээний стандарт хангуулах, шинээр зоогийн газар байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлэх, өвлийн эвент, аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх, НИТАЖ-ын сургалт зохион байгуулах, бүсийн коллежид аялал жуулчлалын ангийн суралцагчдын тоог нэмэгдүүлэх, AR VR технологи ийг ашиглан түүхэн үйл явдлыг харуулах үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг 7 зорилт, 10 арга хэмжээг 80 хувьтай хэрэгжүүлж ажиллалаа.	70%	30%	Зорилтыг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тайлагнаагүй хангалтгүй, тайлан шаардлага хангаагүй тул үнэлгээг бууруулж 30 хувиар үнэлэв.
21	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тогтоолд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан ба Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	30%	Зорилтыг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тайлагнаагүй хангалтгүй, тайлан шаардлага хангаагүй тул үнэлгээг бууруулж 30 хувиар үнэлэв.
22	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Байгууллагын дотоод журамд 2025 онд ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах талаар төсвийн шууд захирагч нарт чиглэл хүргүүлсэн.	70%	30%	Зорилтыг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тайлагнаагүй хангалтгүй, тайлан шаардлага хангаагүй тул үнэлгээг бууруулж 30 хувиар үнэлэв.

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						
23	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2. ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4. хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6. хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7. захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.8. ЭНЭ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	ХЭЗХНутгийн өөрөө удирдах байгууллагаас 57, Аймгийн Засаг дарга 3 батлан гаргасан хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдөн, хэрэгжүүлэн ажиллаж байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хууль (шинэчилсэн найруулж) 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор Цагийн хязгаар батлах тухай Аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/510 дүгээр захирамжийг аймгийн Засаг даргын захирамжаар хүчингүй болгож Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх шинэчилсэн цагийн хязгаарыг тогтоох тухай” захиргааны хэм хэмжээний актыг Улсын нэгдсэн санд бүртгэлд 2024 оны 04 сарын 25-ны өдрийн 6782 дугаарт бүртгүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%	30%	Заалтын хүрээнд бус хэмжигдэхүйц бусаар тайлан ирүүлсэн. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад заалтын дагуу тайлан хүргүүлэх

